



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 03 өдөр

Дугаар #650 .

Ховд

Үндсэн хөрөнгө худалдан авах  
зөвшөөрөл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 41 дүгээр зүйлийн 41.2.6 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 97 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газрын харилцааны талаарх төрийн үйлчилгээг цахимжуулах, үйлчилгээний хурдан шуурхай байдлыг хангах зорилгоор 2021 онд зохион байгуулсан газар эзэмшүүлэх дуудлага худалдааны орлогоос 10,971,900 /арван сая есөн зуун далан нэгэн мянга есөн зуу/-н төгрөгийг зохих журмын дагуу эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр зарцуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т зөвшөөрч, худалдан авах хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулсан 10,971,900 /арван сая есөн зуун далан нэгэн мянга есөн зуу/-н төгрөгийг 2021 оны 12 дугаар сарын 20-ны дотор буцаан төвлөрүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

3. Худалдан авч буй хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлд тусгаж орлого болгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

ХУДАЛДАН АВАХ ХӨРӨНГИЙН ЖАГСАЛТ

Ховд аймгийн Засаг даргын 2021 оны  
11 дүгээр сарын 03-ны өдрийн  
А/650 дугаар захирамжийн хавсралт



Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/	Зориулалт
1	Киоск цахим машин	Kiosk i5-2th 4gb 128gb ssd lan+usb 23.8 inch	ш	1	4,070,000	4,070,000	Цахим шилжилтийн хүрээнд иргэд өөртөө үйлчлэх ахим үйлчилгээний булан тохижуулах
2	Wi-Fi салгаалгач	TP_LINK TL-WR840N 300mb	ком	1	825,000	825,000	"Газрын харилцаа- цахим шилжилт" аян, мэдээллийн ил тод байдлыг хангах
3	Нард диск	1TB	ш	1	150,000	150,000	
4	Мэдээллийн самбар	Циллиод 240x120 см	ш	1	1,045,000	1,045,000	
5	Хөлтэй самбар	Стикер 180x60 см	ш	4	45,000	180,000	"Газрын харилцаа- цахим шилжилт" аяны мэдээлэл хүргэх
6	Лого үсэг	Циллиод 1 лого 13 үсэг 2 стикер самбар 1 хөшиг	ком	1	227,000	227,000	Цахим шилжилтийн хүрээнд иргэд өөртөө үйлчлэх ахим үйлчилгээний булан тохижуулах
7	Ханын наалт	Хөөсөн 80x70 см	ш	30	4,800	144,000	
8	Материалын үнэ		ком	1	1,490,900	1,490,900	iso 9001 стандартын хүрээнд 5s зарчмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай материалууд
9	Бичиг хэргийн материал	Бичгийн цаас 15 боодол Принтерийн хор 12 ш	ком	1	840,000	840,000	Сумдын газрын даамлуудын өдөр тутмын хэвийн ажллагааг хангах
10	GPS garmin etrex32	8 GB, 2 AA batteries, 2.2" transfective, 65K color TFT	ш	2	1,000,000	2,000,000	Газрын зөрчил маргаан шийдвэрлэх, суурин хээрийн хийх
						10,971,900	

Дүн